



**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
ГАЗРЫН 2017 ОНЫ 06 ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

**2017.06.19**

**1. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ**

**Газрын маргаан шийдвэрлэлтийн талаар:**

Эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрөлгүй дураараа хашаа, гэр, граж, барилга барьсан, эзэмшлийн газраас илүү гаргаж хашаа барьсан, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурваст орсон 10 иргэнд газар чөлөөлөх хугацаатай шаардах хуудас өгснөөс 8 зөрчлийг арилгаж, газрыг чөлөөлүүлсэн.

№	Газрын байршил	Гаргасан зөрчил	Шаардах хуудас хугацаа /хоног/	Шийдвэрлэсэн байдал
1	Дархан сумын 3-р баг Хараагийн 4-р гудамж 42, 44 тоот Б.Ганболд, Д.Мөнхбат	Хашаагаа сунгасан	3	Б.Ганболд хашаагаа татсан
2	14-р баг Хүрээлэнгийн ар иргэн Дорлиг	Дураараа хашаа барьсан	1	Газар дээр нь хашааг нь хураалгасан
3	6-р баг Тээвэрчид 4-р гудамж 47 тоотын залгаа иргэн Нацагдорж	Цахилгааны шугамын хамгаалалтын зурваст байшин барьсан	7	-
4	14-р баг, 2-р хороолол, У.Ирээдүй	2 айлын гарц хааж блокон хашаа барьсан	7	Блокон хашааг буулгасан
5	13-р баг, Их сургуулийн 6-1 тоотын зүүн талд Сүхбаатар	2м сунгасан	7	Модон хашааг буулгасан
6	7-р баг, Найрамдал 3-21	Хашаагаа сунгасан	7	Хашаагаа татсан
7	7-р баг, Замчин 2-49	Хашаагаа сунгасан	7	-
8	6-р баг Ханжаргалн, 7-р баг Сэргэлэн Д.Цэрэн, Н.Нарантуяа	Хашаагаа сунгасан маргаан гаргасан		Хяналтын хэмжилт хийж шийдвэрлэсэн
9	8-р баг Нарантолгойд иргэн Ч.Батболдын дуудлага худалдаагаар авсан газар, 9-р баг иргэн Ж.алиунаа	Шинэ замын далангийн ирмэгт ойртсон учир орц гарц гаргах		Аймгийн Ерөнхий архитектортой хамтарч газар дээр нь очиж зөрчлийг арилгасан



14-р баг, 2-р хороолол, У.Ирээдүй 2 айлын гарц хааж блокон хашаа барьсныг буулгуулсан /2017.05.15/



13-р баг, Их сургуулийн 6-1 тоотын зүүн талд Сүхбаатарын 2м сунгасан модон хашааг буулгасан /2017.05.12/

#### **Газрын дуудлага худалдааны талаар:**

Дархан сумын хэмжээнд газрын дуудлага худалдааг аймгийн Засаг даргын 2017.04.06-ны А/130, 2017.05.16-ны А/210, 2017.05.24-ны А/230 дугаар захирамжаар 3 удаа 10 байршилд, төсөл сонгон шалгаруулалтыг аймгийн Засаг даргын 2017.04.06-ны А/129 дугаар захирамжаар 1 удаа 19 байршилд зарласан.

2 дахь дуудлага худалдааг 2017.06.09-ны өдөр зохион байгуулж 6 нэгж талбарт 9 оролцогч оролцож, 3 нэгж талбарыг 102,5 сая төгрөгөөр зарж орон нутгийн төсөвт оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. 3 дахь дуудлага худалдаа 2017.06.23-ны өдөр зохион байгуулагдана.

Төсөл сонгон шалгаруулалтын төслийн битүүмжилсэн материалыг 2017.06.06-ны өдөр хүлээн авсан. Нийт 24 төсөл ирсэн байна. Аймгийн Засаг даргын 2017.06.06-ны А/244 дугаар захирамжаар төслийг үнэлж, дүгнэлт гаргах комиссыг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж төслийг 2017.06.12-ны өдөр үнэлэх ажил хийгдлээ.

#### **Газар өмчлөлийн талаар:**

Дархан-Уул аймгийн хэмжээнд 2017 онд шинээр 666 иргэнд 85,41 га газар, хуучин хашааны газарт 303 иргэнд 45,93 га газрыг өмчлүүлэхээр байна. Үүнээс: Орхон суманд шинээр 110 иргэнд 8 га, Хонгор суманд 525 иргэнд 75,24 га, Шарын гол суманд 31 иргэнд



2,17 га, хуучин эзэмшиж байсан газарт Дархан суманд 240 иргэнд 17,43 га, Шарын гол суманд 63 иргэнд 30,67 иргэнд өмчлүүлэхээр төлөвлөсөн.

2017.06.15-ны өдрийн

байдлаар Дархан суманд 32 иргэнд 2,7 га, Орхон суманд 68 иргэнд 5,45 га, Хонгор суманд 28 иргэнд 8,5 га газрын өмчлүүлсэн байна.

Дархан-Уул аймгийн хэмжээнд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнээс хойших газрын судалгааг гаргаж, Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумдад газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлэх, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцүүлэг, санал авахаар хүргүүлсэн боловч дорвитой арга хэмжээ авч ажиллахгүй байна.

#### Геодези, зураг зүйн чиглэлээр:

“Ёлт сүрвэй” ХХК-ны хийж гүйцэтгэсэн Голомт банкны оффисын барилга, “Чандмань гурван тэвш” ХХК-ны нийтийн орон сууцны барилгын тэг тэнхлэгийг газарт шилжүүлэх ажлыг хүлээн авч шалган акт үйлдэн барилга эхлүүлэх зөвшөөрөл хүссэн материалд хавсарган барилга хот байгуулалтын хэлтэст хүргүүлсэн.

Дархан сумын 7-р баг “ЭМА ТРЕЙД” ХХК-ны гаргасан өргөдөл хүсэлтийн дагуу газар дээр нь хяналтын хэмжилт хийсэн. Хуучин үерийн ус зайлуулах шугам нь “ЭМА ТРЕЙД” ХХК-ны ар талаар дайран өнгөрдөг бөгөөд уг газар нь тус компанийн эзэмшлийн газарт хамаардаггүй тул шугамыг шинэчлэн солих ажиллагаа нь “ЭМА ТРЕЙД” ХХК-ны эрх ашгийг хөндөөгүй байгааг мэдэгдлээ.

Дархан-Уул аймгийн Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумдын 1:100 000 масштабтай байр зүйн зураг /1968/, газар зүйн нэрийн зураг /1982/, “Геокад” ХХК-ны хийсэн хаягийн зураг /2016/-т оруулсан газар зүйн нэрийг түүвэрлэн харьцуулалт хийж мэдээллийн санд бүртгэсэн.

д/д	1:100000 масштабтай байр зүйн зураг / 1969 онд шинэчилсэн /		Газар нутгийн нэрийн зураг / М1:150000 / / 1982 онд тодруулалт хийсэн /		Хаягын зураг / М1:100000 / / Геокад ХХК-ий хийсэн 2016 он /	
	Уул толгод, давааны нэр	Бусад нэрс	Уул толгод, давааны нэр	Бусад нэрс	Уул толгод, давааны нэр	Бусад нэрс
1	Модот уул	Шийрийн хөндий	Шар	Гозгор	Модот уул	
2	/905.7/		толгой		Их булангийн уул	
3	Баян Хонгор	Уужим	Модот уул		Бурхантын хоолой	
4	уул	булаг	Их булангийн уул		Баян Хонгор уул	
5	Онгот гурван	Бурхантын хоолой	Гүр толгой		Элсэн эрэг	
6	толгой		Баян Хонгор уул		Цайдамын хөндий	
7			Талын толгой			
8			Онгот гурван толгой			
			Цагаан гозгор толгой			
	6		12		3	



Үл хөдлөх хөрөнгийн хаяг дугаар авахаар өргөдөл, хүсэлт ирүүлсэн “Дархан нэхий” ХХК-ний материалыг бүрдүүлж Дархан сумын ИТХ-д хүргүүлснээр тогтоол гаргуулж хаяг, дугаар олгосон.

### Газрын биржийн цахим програм хангамжийн талаар:

Газрын цахим биржийн програм хангамжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байгаа ба 2017 оны 06-р сарын 15-ны өдрийн байдлаар барьцаа-68, үнийн мэдээ-99, ХАА-н түрээсийн үнэ-9 /нийт 176/ бүртгэсэн байна. 2017 оны эхний хагас жилийн байдлаар өссөн дүнгээр барьцаа-264, үнийн мэдээ-965, дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын зарыг тухай бүр байршуулж, олон нийтэд ил тодоор сурталчлан ажиллаж байна.


ХАА-н газрын түрээсийн үнийг Орхон суманд 3 талт гэрээгээр цуглуулж эхэлсэн. Мөн үнийн мэдээг цуглуулахдаа “Ди Би Эс” телевизийн 2017.05.17-ны өдрийн урсгал зараар газар зарна гэсэн 13 иргэнээс мэдээлэл авч цахим биржид бүртгэсэн.

Сар	Нийт	Сонголт	Өөрөөр	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20

Сар	Нийт	Сонголт	Өөрөөр	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян	Баян
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20

### Хяналт шалгалтаар хийсэн ажлын талаар:

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2016 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан “Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, Газрын даамлын ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үүрэг бүрэн хэрэгжиж байгаа эсэх, 2017 оны 03-р сарын 29-ны өдрийн зөвлөгөөнөөс гарсан сумдын Засаг дарга, газрын даамлуудыг мэргэжил арга зүйгээр хангах зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг удирдамжид зааснаар 2017.05.31-2017.06.02-ны өдрүүдэд Орхон, Хонгор, Шарын гол сумдад хяналт шинжилгээ, үнэлгээний багийн ажлын хэсэг ажилласан.



Хонгор сум

Орхон сум



Сум тус бүрээр шалгалтын үр дүнг хүснэгтээр үзүүлбэл:

№	Сумын нэр	Шалгуур үзүүлэлт		Бодит гүйцэтгэл /хувь/	Ажлын байрны тодорхойлолт		Бодит гүйцэтгэл /хувь/
		Авах ёстой оноо	Авсан оноо		Авах ёстой оноо	Авсан оноо	
1	Шарын гол	700	516.8	73.8	100	71.8	
2	Орхон	700	351.9	50.2	100	55	
3	Хонгор	700	201.8	28.8	100	29.1	
<b>НИЙТ</b>		2100	1070.5	50.9	300	155.9	51.9



Шарын гол сум

Сум тус бүрээр нийт 7 шалгуур үзүүлэлтээр шалгасан үнэлгээг үзүүлбэл:

№	Сумын нэр	Геодезийн хэмжилт зуралгал, цэг тэмдэгийн бүртгэл, хамгаалалтын явц /100 оноо/	Инженер хайгуул, мониторингийн ажлын хэрэгжилт /100 оноо/	Газар зохион байгуулалтын төлөвлөлт, хэрэгжилт /100 оноо/	Кадастрын ажлын явц /100 оноо/	Орон зайн мэдээлэл, технологийн ажлын явц /100 оноо/	Дотоод ажлын явц /100 оноо/	Мэдээллийн хадгалалт, хамгаалалт /100 оноо/	НИЙТ АВСАН ОНОО	Боди гүйцэтгэл /хувь/
1	Шарын гол	86	53	80.2	62	78.6	71.4	85.6	516.8	73.8
2	Орхон	50.6	42.8	70	20.2	66	52.3	50	351.9	50.2
3	Хонгор	39.4	18	21	20	55.8	23	24.6	201.8	28.8
<b>НИЙТ</b>		176	113.8	171.2	102.2	200.4	146.7	160.2	1070.5	50.9

Шалгалтын үр дүнгээс харахад Шарын гол сумын газрын даамлын ажлын ажил үүрэг, газрын харилцааны чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа ажил үйлчилгээ нь жигд хэвийн явагдаж байна.

Хонгор сумын хувьд маш хангалтгүй үзүүлэлттэй бол Орхон сумын хувьд ажил үйлчилгээ нь 50 хувийн гүйцэтгэлтэй байна.



### **Нийтлэг гарсан алдаа дутагдал, зөрчлийн хувьд:**

1. Инженер хайгуул мониторингийн ажлын хэрэгжилт хангалтгүй /хянан баталгааны ажлууд, бэлчээрийн фото мониторингийн ажил/
2. Газрын кадастрын мэдээллийн сангийн хөтлөлт /жижүүрийн зураг, нэгж талбарын хувийн хэрэг, улсын бүртгэлийн дэвтрийн хөтлөлт, архивын хадгалалт хамгаалалт/ хангалтгүй
3. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй /хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт гараагүй, судалгаа дүгнэлт байхгүй/, газрыг дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олгодоггүй, Газрын тухай хууль зөрчсөн
4. Хаягжуулалтын ажил удаашралттай
5. Цахим биржийн хэрэглээ байхгүй /www.mle.mn-д үнийн мэдээ, барьцааны бүртгэл байхгүй, дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын зар мэдээ оруулаагүй, цахимаар зохион байгуулаагүй байна/
6. Газрын кадастрын мэдээллийн сангийн “Ланд менежер” програм хангамжийн хэрэглээ хангалтгүй
7. Геодезийн цэг тэмдэгтийн судалгаа хангалтгүй /устсан, тоолсон, гэм буруутай этгээдийг олж тогтоосон, сэргээн босгох талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ аваагүй/
8. Хонгор, Орхон сум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй
9. Хонгор, Шарын гол, Орхон сумууд газрын төлбөрийн хэмжээг тогтоосон сумын ИТХ-ын тогтоолыг ГНС-ийн ангилалын дагуу шинэчлэн батлуулаагүй
10. Ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үүргийг бүрэн хэрэгжүүлж ажилладаггүй
11. Газар өмчлөлийн ажлыг эрчимжүүлэх ажил огт хийгдээгүй, газрын гэрээ дүгнэдэггүй

Дээрх хяналт шалгалт тус бүрээр дүгнэлт гаргаж Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга, Газрын удирдлагын хэлтсийн дарга нийт ажилтнуудад танилцуулж, зөвлөмж гарган, “Гүйцэтгэл сайжруулах ажлын төлөвлөгөө” гарган хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын газрын даамлуудад албан тоотоор хүргүүлж, 2017 оны 11 дүгээр сард дахин шалгалтыг хийхээр болсон.

### **Газрын төлбөрийн талаар:**

2017 онд газрын төлбөрийн орлогоос 652,0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээс 2017 оны 06-р сарын 14-ны өдрийн байдлаар 270.9 сая төгрөгийг төвлөрүүлж, төлбөрийн гүйцэтгэл 41.5 хувьтай явж байна.

2017 оны 5-р сарын 31-ны өдрийг дуустал газрын төлбөрийн гүйцэтгэлийг сум тус бүрээр үзүүлбэл:



Сумын нэр	1-5 сарын гүйцэтгэл					
	Жилээр	Хагас жил	1-3 сар	4-5 сар	Нийт	Биелэлт
Шарын гол	58,000,000.00	29,000,000.00	9,714,006.10	3,416,402.60	13,130,408.70	22.64
Хонгор	205,000,000.00	102,500,000.00	20,645,044.00	15,874,903.00	36,519,947.00	17.81
Орхон	39,000,000.00	19,500,000.00	8,851,708.00	26,205,460.00	35,057,168.00	89.89
Дархан	350,000,000.00	175,000,000.00	109,158,801.39	59,915,102.17	169,073,903.56	48.31
<b>НИЙТ</b>	<b>652,000,000.00</b>	<b>326,000,000.00</b>	148,369,559.49	105,411,867.77	253,781,427.26	38.92

Газрын төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу сумдад хийгдсэн Шалгалтын үр дүнгээр нийт 5067 гэрээнээс 661.9 сая төгрөгийг жилд төвлөрүүлэхээр байна. Иймд гэрээгээр ногдуулсан жилийн төлбөрийн ногдлоор тухайн газар эзэмшигч, ашиглагч нэг бүрээр захирамж гарсан өдрөөс хойш тооцож, газрын төлбөрийг төлж байсан эсэхэд хяналтыг тавьж, өмнөх оны илүү дутуу үлдэгдлийг гаргахаар аймгийн Татварын хэлтэст 2017.05.16-ны өдрийн 374 тоот албан бичгээр болон [Darkhan@mta.gov.mn](mailto:Darkhan@mta.gov.mn) цахим хаягаар хүргүүлсэн. Үүнд:

Шарын гол сум 417 гэрээнээс 68.8 сая төг  
Хонгор сум 1237 гэрээнээс 184.3 сая төг  
Дархан сум 546 ААНБ-аас 316.8 сая төг  
592 иргэн 78.8 сая төг  
980 Амины орон сууц 6.7 сая төг

1295 аж 6.5 сая төг

Газрын төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх, тасалдаж байгаа орлогын хэмжээг нэмэгдүүлэх, газар эзэмших, ашиглах гэрээг дүгнүүлэх зорилгоор “Мобиком корпораци”-тай хамтран “МОБАЙЛ СУРТАЛЧИЛГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭ”-г явуулахаар 2017.05.30-ны өдөр 4100 газрын гэрээтэй ИААНБ-д хүргүүлэхээр судалгаа гарган Мобикомийн [ulamundrakh.kh@mobicom.mn](mailto:ulamundrakh.kh@mobicom.mn) цахим хаягаар хүргүүлсэн. Өмнө нь уг үйлчилгээг авахад тогтмол үнэ ханштай байсан бол одоо хэрэглэгчийн төрлөөр /тухайлбал: дараах, картын гм/ ангилж, үйлчилгээний хөлс бодогдох болсон тул боловсруулалтын шатанд явагдаж байгаа тул түр хугацаагаар хойшлогдоод байна. Энэ сард багтаан уг үйлчилгээ явагдана.



## Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн талаар:

2017.05.19-06.19



## 2. БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

**“Хот байгуулалтын тухай” хуулийн 23, 24-р зүйлийн хэрэгжилтэнд холбогдох байгууллагуудтай хамтран үзлэг хийх, хяналт тавьж ажиллах:**

- Дархан сум. 9-р баг. Иргэн Ариунаагийн үйлчилгээний барилгын ерөнхий төлөвлөгөөг хянан шалгаж газар дээр нь тохируулан өөрчилсөн.
- Дархан сум. 8-р баг. Шинэ замын дагууд барилга баригдаж эхлэх гэж байгаатай холбоотойгоор газар дээр нь хэмжилт хийж, төлөвлөлтийн хувилбар боловсруулан ерөнхий архитекторт танилцуулсан.
- “Дархан сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК-ны хүсэлтийн дагуу Дархан-Уул аймаг, Дархан сум, 5-р багт байршилтай “Горгаз” ХХК нь автомашин хийгээр цэнэглэх станцын газар шорооны ажил гүйцэтгэж байх явцдаа цахилгааны кабель гэмтээснийг холбогдох удирдлагуудад мэдэгдэж зөрчлийг арилгуулсан тухай албан тоотыг хүргүүлж ажилласан.

### **Ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын чиглэлээр:**

- Шүтэн уул” ХХК-н эзэмшдэг үйлдвэрийн зориулалттай газрыг шилжүүлж байршуулах асуудлыг ерөнхий архитекторт тавьж шийдвэрлүүлсэн.
- “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд Дархан суманд хийгдэх ажлуудын байршлын зургуудыг хийж, ба Дархан сумын 7.14.30-р хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгавар боловсруулсан
- Шинээр 2 байршилт / шүүхийн шинжилгээний оффис барих, Хараа Ерөө голын захиргааны барилга барих/ тодорхойлж шийдвэрлэсэн.
- Эх загвар зураг 3ш хянаж баталсан. Үүнд:
  - Дархан сум 8-р багт авто үйлчилгээний барилга
  - Дархан сум. Өмнөд үйлдвэрийн районд баригдах авто үйлчилгээ
  - Дархан сум. Өмнөд үйлдвэрийн районд баригдах “Ганбат тулга” ХХК-н үйлдвэрлэл, үйлчилгээний барилга





### **Засгийн газрын 68 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:**

- Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл аваагүй өмнөд үйлдвэрийн районд байршилтай “М-Ойл” ШТС-н барилга, “HSMG” ХХК-ны гадна бохир усны шугамын ажил, Дархан сумын 9-р багт байршилтай Иргэн Совинбаяр, “Баргил Тех” ХХК-ны шохойны үйлдвэр зэрэгт хугацаатай мэдэгдэх хуудас болон мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.

### **Барилгын ажил эхлэх зөвшөөрөл олгосон байдал**

- Дархан-Уул аймаг, Дархан сум 9-р багт байршилтай Иргэн Р.Совинбаярын нийтийн орон сууцны зориулалттай барилгын техникийн бичиг баримтыг хянаж үзэн барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг олгосон.

- Дархан-Уул аймаг, Дархан сум 5-р баг болон Хонгор сумын 1-р багт байршилтай “Горгаз” ХХК-ны автомашин хийгээр цэнэглэх станцын барилгын техникийн бичиг баримтыг хянаж үзэн барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг олгосон.

- Дархан-Уул аймаг, Дархан сум 12-р багт баригдах Голомт банкны үйлчилгээний зориулалттай барилгад барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл хүссэн дагуу барилгын техникийн бичиг баримтын иж бүрдлийг хянаж үзэн барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг олгосон.

- Дархан-Уул аймаг, Дархан сум, 7-р багт байршилтай Иргэн Г.Эрдэнэчимэгийн авто үйлчилгээний зориулалттай барилгад барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл хүссэний дагуу барилгын техникийн бичиг баримтыг хянаж үзэн барилгын техникийн бичиг баримт дутуу байсан тул бичиг баримтын бүрдэлтийг ханган дахин хүсэлтээ гаргах тухай албан тоотыг хүргүүлж ажилласан.

- Дархан-Уул аймаг, Дархан сум 5-р багт байршилтай Хараагийн дарь эх ламын Гэцогдаржаалин хийдийн шинээр баригдах барилгын техникийн бичиг баримтыг хянаж үзэн барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг олгосон.

- Дархан сумын 12-р баг. 14-р хороололд байрлалтай “Мираклленд” ХХК-н 9 давхар орон сууцны барилгын ажил эхлүүлэх техникийн бичиг баримтуудтай танилцаж, 54 айлын 9 давхар орон сууцны барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг олгов.

### **Засгийн газрын 69 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:**

- Дархан-Уул аймаг, Дархан сум, 8-р багт байршилтай Иргэн О.Мөнхцэцэгийн үйлчилгээ, орон сууцны зориулалттай барилгыг барилга ашиглалтад оруулах комисс ажиллуулах хүсэлт гаргасны дагуу барилгын техникийн бичиг баримтыг хянаж үзэхэд барилга байгууламжийн зураг төслийн экспертизийн ерөнхий дүгнэлт дутуу байсан. Иймд баригдсан барилгадаа норм, дүрмийн дагуу баригдсан эсэх хөндлөнгийн дүгнэлт гаргуулах тухай албан тоотыг хүргүүлж ажилласан.

- 2016 онд орон нутгийн хөгжлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн “Жишиг хороолол-3” төслийн хүрээнд Дархан сумын 9,10 дугаар багт “Свебау Хаус” ХХК-ны хийж



гүйцэтгэсэн ногоон байгууламж, хашаажуулалтын ажил чанарын шаардлага хангагдаагүй талаар хугацаатай албан тоотыг хүргүүлж ажилласан.

- 2013-2017 онуудад Дархан-Уул аймагт ашиглалтад орсон барилга байгууламжийн гадна тохижилт, авто зам, ногоон байгууламжийн ажил нь дутуу хийгдсэн 11 иргэн, ААНБ-д хугацаатай албан тоотыг хүргүүлж ажилласан.

- “Дархан дуулга” ХХК-с ирсэн 2017.06.12-ний 17/12 тоот албан бичгийн дагуу Дархан сум 13-р хороололд баригдаж байгаа цэцэрлэгтэй 50 айлын орон сууцны барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авахад бүрдүүлсэн тухайн үеийн баримт материалыг хавсралтаар хуулбарлан хүргүүлээ.

#### **Барилгын тусгай зөвшөөрөл олгох журамд заасны дагуу:**

- Сонголон хайрхан” ХХК-ийн Бетон зуурмаг үйлдвэрлэлийн ын 3.5.2 заалтын дагуу бүрдүүлсэн техникийн бичиг баримт, хийж гүйцэтгэсэн ажлын тайланг үндэслэн БМҮ-н холбоонд тодорхойлолт гаргаж өгөв.

- Барилгын зураг төслийн “ЗТК” ХХК-ны тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай хүсэлтийн дагуу бичиг баримтыг хянаж үзэн БХТ-д тодорхойлолтыг гаргаж өгч ажилласан.

#### **Барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр:**

- Монголын барилга материалын үйлдвэрлэгчдийн холбоотой зөвлөлдсөний дагуу БМҮ-н холбооны экспертийн багийнхан Дархан-Уул аймагт ажиллаж, барилга материалын үйлдвэрлэл шинээр эрхэлж байгаа ААНБ-д тусгай зөвшөөрөл авах талаар зөвлөж, ажлын байр үйлдвэрийн технологитой танилцаж газар дээр нь ажилласан.

- Дархан суманд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа авто зам засвар, шинэчлэлтийн ажилд хэрэглэгдэж байгаа авто замын бордюрийг “Чанар баталгаажуулсан гарал үүслийн гэрчилгээ, лабораторийн батламжтай байх” шаардлага хангасан бүтээгдэхүүн хийц эдлэлийг авч ашиглаж байх тухай албан тоотыг “Сэлэнгэ АЗЗА”, “Дархан АЗЗА”, “ОДНД” ХХК-уудад хүргүүлж ажиллалаа

- Барилгын хөгжлийн төвөөс ирсэн 2017.05.31-ний 1/1232 тоот албан бичгийн дагуу Дархан-уул аймагт барилга материалын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-уудын судалгаа мэдээллийг хүснэгтээр хүргүүлсэн.

- Барилга материалын үйлдвэрлэл эрхлэгч байгууллагуудад бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалтын улирлын тайлан мэдээг тогтмол хугацаанд ирүүлж байх тухай албан бичиг хүргүүлсэн

- БХБЯ-с ирүүлсэн албан бичгийн дагуу Хөгжлийн банкнаас зээл авсан барилгын материалын ААНБ-н талаарх мэдээллийг гаргахын тулд ирүүлсэн хүснэгтийн дагуу тайлан ирүүлэх тухай албан бичгийг ААНБ-уудад явуулсан.



## **Инженерийн хангамжийн техникийн нөхцөлийн хэрэгцээт ачаалал 15-18-р**

### **үлгэрчилсэн загвар мөрдөж ажиллах:**

- Дулааны техникийн нөхцөлийн хэрэгцээт ачааллыг 6 иргэн, ААНБ-д
- Ус хангамж, ариутгах татуургын хангамжийн хэрэгцээт ачаалалыг нэг иргэн, ААНБ-д тооцож гаргаж өгсөн байна.
- “ДДС” ТӨХК дээр техникийн нөхцөл олгох хуралд оролцож 11 иргэн, ААНБ-н гаргасан хүсэлтийг хэлэлцэж, 9 иргэн ААНБ-д техникийн нөхцөл олгох шийдвэр гаргалаа.

### **Улс, орон нутаг болон бусад эх үүсвэрээс санхүүжилттэй шинээр болон шинэчлэн боловсруулж буй хот байгуулалтын баримт бичигт санал өгөх, гүйцэтгэгчтэй**

#### **хамтран ажиллах:**

- Дархан-Эрдэнэтийн уулзварт шинээр хийх 4 км авто замын гэрэлтүүлэг, тойрог уулзвараас урагш 3,3км авто замын гэрэлтүүлэг, тойрог уулзвараас урагш Хонгор сумын цайдам хүртэлх авто замын гэрэлтүүлгийн зураг хянаж, санал өгсөн.
- Дархан хар төмөрлөгийн үйлдвэрийн дулааны шугамын зургийн даалгаврыг хянасан.
- “Бориг тэс” ХХК-н хийсэн ажлын тухай инженерийн шугам сүлжээний байгууллагуудаас ирүүлсэн дүгнэлттэй танилцлаа.
- Дархан сумын 3,31-р хорооллын инженерийн зарим шугам сүлжээний урьдчилсан тооцоог хийж гаргасан.

### **Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн заавар”-ыг мөрдөж ажиллах, мэдээллийн сан бүрдүүлэх**

- Жижүүрийн ерөнхий төлөвлөгөөний хөтлөлтөд баяжилт хийгдлээ.
  - “Минж проперти” ХХК-н 80 айлын орон сууц
  - Дархан сум. 5-р баг дах 100 хүүхдийн цэцэрлэг
  - Дархан сум. 9-р баг. “Дашваанжил” ХХК-н АХЦС эдгээр барилгуудын атрибут мэдээллийг нэмж бичлээ.

#### **Ирсэн албан бичгийн дагуу хийсэн судалгааны ажил:**

- БХБЯ-с ирүүлсэн хүснэгтийн дагуу Хөгжлийн банкнаас Дархан хотод хэрэгжсэн ажлын судалгааг гаргаж мэйл хаягаар хүргүүлсэн.
- Газар хөдлөлийн байнгын ажиллагаатай зөвлөлөөс ирүүлсэн албан бичгийн дагуу Инженерийн шугам сүлжээний 5 байгууллагаас барилгуудын судалгаа авч нэгтгэн холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.
- ХХБ-с ирсэн албан бичгийн дагуу тус банкны ерөнхий төлөвлөгөөний зургийг олж хуулбарлан хүргүүллээ.
- Дархан сумын хуучин Дарханд байрлалтай барилгуудын тоо хэмжээ, судалгааг гаргах ажлыг эхлээд байна. Энэ судалгаа нь ОБЕГ-т хүргэгдэнэ.



- “МУ-н ЗГ-н газар хөдлөлийн байнгын ажиллагаатай зөвлөлөөс ирүүлсэн албан бичгийн дагуу манай аймагт байгаа томоохон 11 үйлдвэр ААНБ-д барилгын хувийн хэрэг бүрдэлтийн судалгаа авахаар албан бичиг хүргүүллээ.
- “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх БАЗ-өөс ирсэн судалгааны албан бичгийг 24 агентлагт хүргэж судалгааг цуглуулж, нэгтгэн хүргүүлсэн.


### БУСАД АЖИЛ

#### Сургалт зохион байгуулсан

Сумдын даамлуудын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор ХААИС-ийн эрдэмтэн багш нартай хамтран Сургалтын удирдамж гарган батлуулсан. Үүнд:

№	Сургалтын чиглэл	Зохион байгуулагдах хугацаа	Хариуцах багш
1	Бэлчээрийн газрын төлөв байдлын мониторинг	2017.06 сар /1-р 10 хоног/	А.Нарантуяа
2	ГНС-ийн тайлан	2017 оны 8сар /2-р 10 хоног/	Ч.Амармэнд
3	ГЗМС-ийг газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд ашиглах	2017 оны 09 сар	П.Содгэрэл
4	Тохиромжтой байдлын үнэлгээ	2017 оны 10 сар	Л.Пүрэвээ
5	Газар ашиглалтын төлөвлөгөө боловсруулах	2017 оны 11 сар	А.Нарантуяа

Байгууллагын 2017 оны сургалтын төлөвлөгөөний дагуу Фото мониторингийн аргаар бэлчээрийн ургац, даац шинж чанарыг тодорхойлох, Sample point програм хангамжид тооцоолох арга аргачлалд Хонгор сумын даамал Н.Мөнхцэцэг, Орхон сумын даамал М.Халиун нарыг оролцуулж сургалтад хамрууллаа. Сургалтын үр дүнд даамлууд сум тус бүрээр Бэлчээр ашиглалтын хэсгийг 2017.08 дугаар сарын эхний 10 хоногт тогтоож бэлчээрийн ургацыг тодорхойлохоор даалгавар авсан.



ХААИС-ийн арын талбайд дадлага хийсэн /2017.06.08/



### Нийгмийн хариуцлагынхаа хүрээнд

- Дархан сумын иргэн хөгжлийн бэрхшээлтэй Э.Шинэбаяр хүүд 7-р баг Зурагтын ар 2-16 тоотод гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар олгож сэтгэлийн дэм өгсөн.



- Дархан сумын өрх толгойлсон иргэн Э.Мөнхцэцэгт гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар олгож хашааг нь барьж өгсөн.



- Дархан сумын иргэн О.Мөнхтулга хүүд 15-р баг Мангирт 6-р хэсэг 15 а тоотод гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар олгож, 15-р багаас гэр орон сууцны асуудлыг шийдвэрлэхээр болсон.



- Аймгийн ЗДТГ-аас санаачилсан дугуйн зогсоолтой болох ажлыг дэмжиж байгууллагынхаа гадна талбайд дугуйгаар ирэх иргэдэд зориулж дугуйн зогсоолтой болсон.



### Угтах үйлчилгээг нэвтрүүлж ажилласан

№	Хийгдсэн ажил	Үйл ажиллагаа	Тоо хэмжээ	Он, сар, өдөр
1	Иргэдээ Угтах үйлчилгээ	ГХБХБГ-т шинээр угтах үйлчилгээг нэвтрүүлж байгаатай холбогдон хаяг, тохижилтийн ажлыг хийж гүйцэтгэсэн Угтах үйлчилгээндээ иргэдийн өргөдөл, тодруулах хуудас өгөх асуусан асуултанд нь хариулт өгч ажилласан.	Өдөр бүр	2017.05.28-06.15 хүртэл
2	Иргэдээ Угтах үйлчилгээ	Түгээмэл асуулт: Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх, хугацаа сунгах, хаяг нэр солих, өөрчлөх Өмчлөх эрхийн гэрчилгээг шилжүүлэх, худалдах Эзэмшиж байсан газраа өмчлөх, зориулалт өөрчлөх Банкны барьцааны талаар гэх мэт асуултанд хариулт өгч холбогдох мэргэжилтэнд холбох үйлчилгээг үзүүлсэн	50 иргэнд	2017.06.02-аас
3	Мэдээлэл зөвөлгөө өгөх нээлттэй утас	2017 онд “Мэдээлэл зөвлөгөө өгөх, нээлттэй утас”-ыг шинээр нэвтрүүлсэн бөгөөд иргэдийн асуултанд хариу өгч холбогдох мэргэжилтэнтэй холбон ажиллаж байгаа	25 хүнд	2017.05.18-аас одоог хүртэл
<b>НИЙТ</b>			75 иргэн	





## Мэдээлэл технологийн чиглэлээр

Байгууллагын цахим болон фэйсбүүк хуудсанд 17-н мэдээ мэдээллийг оруулж орон нутгийн Ди би эс, ЛХА, Аа жи би телевизүүдэд 2 удаагийн дуудлага худалдаа зохион байгуулах тухай мэдээллийг хийх ажлыг зохион байгуулж ажилласан. Мөн өдөр тутам байгууллагын сервер болон сүлжээний хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.

Дархан-Уул аймгийн 2017 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг байгууллагын цахим болон фэйсбүүк хуудсанд шинэ технологи ашиглаж сурталчлах ажлыг хийж байна.

## Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулсан

2017 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Дархан Олон улсын худалдааны төвийн гадна талбайд нээлттэй хаалганы өдрийг шинэлэг хэлбэрээр зохион байгуулж үүнд кадастрын зураг, газар өмчилж аваагүй тодорхойлолт, газрын төлбөрийн мэдээлэл, лавлагаа г.м, нээлттэй хаалганы өдрөөр зөвлөгөө мэдээллийг нийт 74 иргэнд өгч, 5-н төрлийн 150 ширхэг гарын авлагыг хэвлэн иргэдэд тараасан.



- Байгууллагын гадна зам талбайн тохижилтын зураг төслийг хийж гаргасан.
- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр “Байгаль орчин аялал жуулчлалын газар”-ын хамт олонтой хамтран “Миний Монгол” цэцэрлэгт хүрээлэнд хүүхдүүдийн дунд хөгжөөнт тоглоом, уралдаан тэмцээн зохион байгуулж явууллаа.
- Байгууллагынхаа гадна 78,3м<sup>2</sup> явган зам талбайн тохижилт хийх ажлыг зохион байгуулж хяналт тавьж ажиллав.
- Мэргэжилтэн бүр эхний хагас жилийн үр дүнгийн гэрээний биелэлт
- Засгийн газрын үйл ажиллагааны ажлын тайлан
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны тайлан
- Хууль тогтоомжийн биелэлтийн тайлан гаргасан
- “Эрүүл хот” дэд хөтөлбөрт өгөх ажлын саналуудыг нэгтгэн ЗАА-д хүргүүлсэн
- Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан Гамшгаас хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн дагуу 2 цагийн сургалтад хамрагдсан.
- Дархан сумын хэмжээнд байрлалтай бүх барилгуудын тоо хэмжээ, судалгааг гаргах ажлыг эхлээд байна.



ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

С.БАТБИЛЭГ

/Архив, бичиг хэргийн эрхлэгч/

ТАЙЛАН ГАРГАСАН:

Х.ТУУЛ

/Инженерийн байгууламжийн асуудал хариуцсан  
мэргэжилтэн/

Ц.ЧУЛУУНЦЭЦЭГ

/Газрын төлбөр, татвар үнэлгээ хариуцсан  
мэргэжилтэн/

ТАЙЛАН ХЯНАСАН:

А.НАРМАНДАХ

/Газрын удирдлагын хэлтсийн дарга/

Х.ОЛОНБАЯР

/Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга/